



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 2 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 42

Улаанбаатар  
хот

Улсын Их Хурлын тогтоолын  
хэрэгжилтийг хангах тухай

Улсын Их Хурлын 2016 оны 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хүлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.

2. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2017 оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай.


3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хүнд даацын, тусгай зориулалтын 239 км авто зам, Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн мэдэлд шилжүүлсэнтэй холбоотойгоор тус компанид Хөгжлийн банкнаас олгосон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг тухайн төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд шилжүүлж, холбогдох гэрээг Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хооронд шинэчлэн байгуулахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгасугай.

4. “Төсөл санхүүжүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 80 дугаар тогтоол, “Тавантолгойн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 261 дүгээр тогтоол, “Усан цахилгаан станц барих тухай” Засгийн газрын 2013 оны 375 дугаар тогтоолын хүрээнд “Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн барих 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төсөл”, “Эгийн голын 220 МВт хүчин чадалтай усан цахилгаан станцыг барих төсөл”-д олгосон санхүүжилтийн үлдэгдлийг Засгийн газрын 2013 оны 261 дүгээр тогтоолд заасан нөхцөлөөр Хөгжлийн банкнаас үргэлжлүүлэн үндсэн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, холбогдох гэрээг Эрчим хүчний яам, Хөгжлийн банкны хооронд шинэчлэн байгуулахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д тус тус даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгойн цахилгаан станцын төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 261 дүгээр тогтоолын 1, 3 дугаар зүйлийн “төрөөс” гэснийг хасч, 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зээлийг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлд давуу эрхийн хувьцааны өмчлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д зөвшөөрсүгэй.”

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын санхүүжилтийн тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 449 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН